

**“2024 ОНЫ ЦУСНЫ ДОНОРЫН ДЭЛХИЙН ӨДӨР”-ИЙГ  
ТЭМДЭГЛЭН ӨНГӨРҮҮЛСЭН  
ТУХАЙ ТАЙЛАН**

Улаанбаатар хот

2024.06.18

**1. “Цусны донорын Дэлхийн өдөр”-ийн бэлтгэл ажлыг хангах**

Ерөнхий захирлын 2024 оны 5 дугаар сарын 07-ны өдрийн А/28 дугаар тушаалаар ЦДДӨ тэмдэглэн өнгөрүүлэх Ажлын хэсгийг 13 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж ажлын хэсгийн ахлагчаар Захиргаа, маркетингийн албаны даргыг томилсон. Ажлын хэсэг 2024 оны ЦДДӨ-ийг тэмдэглэн өнгөрүүлэх удирдамж, арга хэмжээнд шаардлагатай зардал 13,5 сая төгрөгийн төсвийг ерөнхий захирлаар батлуулж, ДЭМБ-ын Монгол дахь суурин төлөөлөгчийн газарт хүсэлт тавьж санхүүжилтийг шийдвэрлүүлсэн.

Аймаг, Нийслэлийн эрүүл мэндийн газар, Бүсийн оношилгоо эмчилгээний төв, нэгдсэн эмнэлгийн дарга, захирал наарт уг өдрийн арга хэмжээг харьяа нутаг дэвсгэртээ зохион байгуулж хамтран ажиллахыг хүссэн албан бичиг, ДЭМБ-ын удирдамжийг орчуулгын хамт хүргүүлж чиглэл өгсөн. Ажлын хэсэг ЦДДӨ-ийг тэмдэглэн өнгөрүүлэх бэлтгэл ажлын төлөвлөгөө, 6 сарын 14-ний өдрийн хүндэтгэлийн арга хэмжээний хөтөлбөрийг гарган чиглүүлж арга хэмжээ зохион байгуулалт сайтай болж өнгөрлөө.

ДЭМБ-ын удирдамж, холбогдох тушаал шийдвэр, мэдээллийг төвийн цахим хуудаст байршуулан ил тод нээлттэй байдлыг хангасан.

Хорь гаруй эмнэлэг эрүүл мэндийн байгууллага, компани аж ахуйн нэгжид албан бичиг хүргүүлж уг арга хэмжээг хамтран тэмдэглэхийг уриалснаас Улсын нэгдүгээр төв эмнэлэг, Хавдар судлалын үндэсний төв, Таван богд интернэйшнл ХХК, АПУ Дэйри ХХК, Ундрам Хан Хангай ХХК, Caffe Bene Mongolia, М-Си-Эс Кока-Кола ХХК, Голомт банк зэрэг 10-аад байгууллага ивээн тэтгэж хамтран зохион байгуулав.

**2. Цусны донорын Дэлхийн өдөр-ийн Хүндэтгэлийн арга хэмжээ**


2005 оны 5 сард болсон 58 дахь удаагийн Дэлхийн Эрүүл Мэндийн Чуулга уулзалтын үеэр сайн дурын, авлагагүй цусны доноруудыг идэвхжүүлэх, тэднийг дэмжих зорилтыг олон улсын эрүүл мэндийн байгууллагын удирдлагууд санал нэгтэйгээр дэмжиж, WHA58.13 тогтоолоор жил бүрийн 6 дугаар сарын 14-ний өдрийг Цусны донорын Дэлхийн өдөр болгон тэмдэглэх шийдвэрийг гаргасан. Уг тогтоолоор гишүүн орнууд зохих удирдамжийн дагуу бус нутгийн хэмжээнд цус, цусны бүрэлдэхүүн хэсгийг цуглуулах үйл ажиллагааг тасралтгүй зохион байгуулах, эмнэлгийн хэрэгцээнд нийцсэн аюулгүй цус, цусан бүтээгдэхүүнүүдийг бэлтгэхэд дэмжлэг үзүүлэхийг уриалсан билээ.

Монгол Улсын Цусны алба энэхүү Цусны донорын Дэлхийн өдөр”-ийн хүндэтгэлийн арга хэмжээг Нийслэл УБ хот төдийгүй Аймаг орон нутагт “Амьдрал бэлэглэсэн 20 жил: Цусны донор танд баярлалаа! уриан дор нэгэн зэрэг тэмдэглэн өнгөрүүллээ.


“Амьдрал бэлэглэсэн 20 жил: Цусны донор танд баярлалаа.” уриан дор зохион байгуулагдаж буй энэ жилийн үйл ажиллагаа нь 20-н жилийн ойг тодотгооос гадна, донорыг алдаршуулан, тэдний бэлэглэсэн цус олон сая үйлчлүүлэгчдэд амьдрал бэлэглэж байгааг онцлохыг зорьсон. Мөн “Цусны донорын Дэлхийн өдөр”-ийн гол анхаарал хандуулах асуудал нь цусны албадууд ололт амжилтгаа эргэн харах, тулгарч буй сорилтуудыг тодорхойлох, цаашид аюулгүй, чанарын шаардлага хангасан цус, цусан бүтээгдэхүүнийг үйлчлүүлэгчдэд хүртээмжтэй болгоход анхаарлаа хандуулахыг үүрэг болгохын хажуугаар

дэлхий нийтээрээ цус, сийвэн, ялтас эсийн донорууддаа талархал илэрхийлэн, ард иргэдийг цус бэлэглэх аянд нэгдэхийг уриалж байна.

Цус сэлбэлт судлалын үндэсний төвөөс Цусны донорын Дэлхийн өдөр"-ийн арга хэмжээг ЭМЯ, МУЗН, МДХ, Баянзүрх дүүргийн ИТХ, ЗДТГ-тай хамтран Жанжин Клубийн Соёлын ордонд зохион байгуулж Хүндэтгэлийн арга хэмжээг Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн Ерөнхий захирал, АУ-ны доктор, профессор Н.Эрдэнэбаяр нээж, Амьдрал бэлэглэсэн 20 жил: Цусны донор танд баярлалаа! илтгэл тавилаа. Азийн цус сэлбэлтийн холбооноос цусны донорын Дэлхийн өдрийн 20 жилийн ойн арга хэмжээг нийт гишүүн орнуудыг оролцуулан нээлттэйгээр шууд дамжуулахаар зохион байгуулсны дагуу Цус сэлбэлт судлалын үндэсний төв уг арга хэмжээг шууд дамжуулж бусдын хүртээл болгохын дээр бусад улс орнуудын туршлагаас суралцлаа. Мөн үндэсний хэмжээнд өөрийн пейж хуудсаараа дамжуулав.



Уг арга хэмжээнд Эрүүл мэндийн яамны эмнэлгийн тусламж, үйлчилгээний газрын дарга А.Өнөржаргал оролцож мэндчилгээ дамжуулсан бол МУЗН-ийн Ерөнхий нарийн бичгийн дарга хатагтай Н.Болормаа цахимаар мэндчилгээ дэвшүүлэв.



МУЗН-ийн Эрүүл мэнд нийгэм хамгааллын газрын дарга Б.Гантулга, Монголын донорын холбоо ТББ-ын ерөнхийлөгч М.Сосорбарам, Баянзүрх дүүргийн ИТХ-ын ажлын албаны дарга Ч.Мэндсайхан нарын хүндэт зочид оролцов. Уг хүндэтгэлийн арга хэмжээнд хүрэлцэн ирсэн хүндэт зочид, цусны донор, сайн дурын ажилтан, улаан загалмайчид, ард иргэд Эрүүл мэнд, Банк санхүү, Хэвлэл мэдээлэл, Цэрэг, цагдаа, хууль, хүчний байгууллагуудын хамт олонд Цусны донорын Дэлхийн өдрийн 20 жилийн ойн баярын мэнд хүргэв. Мэдээллийн санд бүртгэлтэй нийт цусны доноруудад цусны донорын Дэлхийн өдрийн мэнд хүргэж, Урилга илгээсэнд цусны донорууд баяртай байна.



Цусны донорын Дэлхийн өдрийг тохиолдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар 120 буюу түүнээс дээш цус, цусны бүрэлдэхүүн хэсгээ өгсөн Хүндэт донор

Ч.Гантулга, С.Гантулга, Р.Ариун-Эрдэнэ, С.Соддэлгэр нарыг “Шударга журам” медалиар шагналаа.



Сайн дурын, авлагагүй цусны донорын эгнээг өргөжүүлэх, цус, цусан бүтээгдэхүүний байнгын нөөцийг бүрдүүлэх, сая сая хүний эрүүл мэнд, амьдралын чанарыг дээшлүүлэх, алтан амийг аврах ариун үйлсийн төлөө тогтвортой хамтран ажиллаж ирснийг үнэлэн, “Цусны донорын Дэлхийн өдөр”-ийг тэмдэглэж эхэлсний 20 жилийн ойг тохиолдуулан Баянзүрх дүүргийн ИТХ, ЗДТГ-ыг **Цусны доор дүүрэг**, Зэвсэгт Хүчний Хуурай Замын Цэргийн Командлал, Этүгэн Их Сургуулийг “Цусны доор хамт олон”-оор шалгаруулж өргөмжлөв.



ЭМЯ-ны Эмнэлгийн тусламж үйлчилгээний газрын дарга А.Өнөржаргал, МУЗН-ийн Эрүүл мэнд нийгэм хамгааллын газрын дарга Б.Гантулга, ЦССҮТ-ийн Ерөнхий захирал Н.Эрдэнэбаяр “Амьдрал бэлэглэсэн 20 жил: Донор танд баярлалаа” уриан дор болж буй 2024 оны Цусны донорын Дэлхийн өдрийн 20 жилийн ойт тохиолдуулан цусны донорын сургалт сурталчилгаа, донор элсүүлэх, цус цуглуулах, нийгэм хүмүүнлэгийн арга хэмжээнд тогтмол оролцож, амжилт гаргасан Монголын донорын холбоо ТББ, Сонгино хайрхан дүүрэг, Баянзүрх дүүргийн Улаан Загалмайн дунд шатны хороодыг “Шилдэг донор элсүүлэгч хамт олон”-оор, Баянзүрх дүүргийн Өсвөрийн Улаан Загалмайчдыг **“ЦУСНЫ ДОНОРЫН ҮЙЛСИЙГ СУРТАЛЧЛАГЧ ШИЛДЭГ ХАМТ ОЛОН”** тус тус шалгаруулан шагнаж алдаршуулав.



Авлагагүй, сайн дурын цусны донорын үйлсийг тогтвортой дэмжиж хамтарч ажилладаг МУБИС-ийн Оюутан хөгжил төвийн багш Т.Дуламрагчаа, Оюутолгой ХХК-ийн Эрүүл мэнд сайн сайхан байдлын зөвлөх Т.Уянга “Нигүүлсэл алтан медаль”, Эко констракшн ХХК-ий Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ахлах ажилтан Э.Тайван, АШУҮИС-ийн Оюутан хөгжил, удирдлагын газрын мэргэжилтэн Б.Түвшинбаатар нарыг “Нигүүлсэл мөнгөн медаль”-иар тус тус шагнаж баяр хүргэлээ.



Монгол Улсын хамгийн олон буюу 217 удаа цус цусны бүрэлдэхүүн хэсгээ өгсөн Топ донор Д.Бум-Эрдэнэ, Д.Эрдэнэчулзуун нарт 20 жилийн баярын мэнд хүргэж Хавдар судлалын үндэсний төв 250-300 төгрөгийн эрүүл мэндийн үзлэгийн эрхээр бэлэг барив.



150 удаа цус, цусны бүрэлдэхүүн хэсгээ өгч “Алтан донор”-ын болзол хангасан Дамдинбазарын Бүдханд, 100 удаа цус, цусны бүрэлдэхүүн хэсгээ өгч “Мөнгөн донор”-ын болзол хангасан Нямаагийн Батцэрэн нарт хүндэтгэл үзүүлж алт, мөнгөн донорын үнэмлэх тэмдэг, онооны урамшууллыг олгож, Улсын нэгдүгээр төв эмнэлэг, Баянзүрх дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, ЗДТГ-аас ивээн тэтгэж мөнгөн шагналаар шагнав.



Сайн дурын, авлагагүй цусны донорын эгнээг өргөжүүлэх, цус, цусан бүтээгдэхүүний байнгын нөөцийг бүрдүүлэх, сая сая хүний эрүүл мэнд, амьдралын чанарыг дээшлүүлэх, алтан амийг аврах ариун үйлсийн төлөө тогтвортой хамтран ажиллаж ирснийг үнэлэн Эко констракшн ХХК“-г Цусны донорын үйлсийг дэмжигч шилдэг байгууллага” болов.

Оюутан залуус эрдэм мэдлэгтэй, энэрэн хайрлах сэтгэлтэй зөв хүн больё уриатай АШУҮИС-ийн Дусал цус-Дүүрэн амьдрал аян, Оюутолгой ХХК-ий уурхайн цогцолборт явуулсан Алсын явуулын цус цуглуулалтыг 20 жилийн ойг тохиолдуулан “Онцлох арга хэмжээ”-гээр шалгаруулж алдаршуулав.



Олон жил тууштай хамтран ажилласан Бурхны сүм дэлхийн сайн мэдээний авралын зар нийгэмлэг, “WeLoveU” Олон улсын байгууллага, Таван богд интернэйшнл ХХК, АПУ ДЭЙРИ, Ундрам Хан Хангай ХХК, Caffe Bene Mongolia, “М-Си-Эс Кока-Кола” ХХК, Голомт банк, Улсын нэгдүгээр төв эмнэлэг, Хавдар судлалын үндэсний төв зэрэг байгууллагын удирдлага хамт олныг 20 жилийн ойг тохиолдуулан “Талархлын эзэд”-ээр тодруулж баяр хүргэлээ.



Энэхүү хүндэтгэлийн арга хэмжээнд Улсын их хурлын гишүүн Э.Бат-Амгалан оролцож мэндчилгээ дэвшүүлж баяр хүргэхийн дээр Баянзүрх дүүргийн төр захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага, ард иргэд, оюутан залуучуудыг иргэний үүрэг, нийгмийн хариуцлагаа биелүүлэн, эрдэнэт хүний амь нас, эрүүл мэндийн төлөөх хүмүүнлэгийн үйлсэд нэгдэж дүүргээрээ цусны донор болж буйд талархал илэрхийллээ.



2024 онд Улсын хэмжээнд 35 буюу түүнээс дээш цус, цусны бүрэлдэхүүн хэсгээ өгсөн 104 цусны донор Хүндэт донорын болзол хангасны 40 нь Нийслэлээс тодорсон байна. Uriлага авч хүрэлцэн ирсэн 30 гаруй хүндэт донорт Хүндэт донорын үнэмлэх, тэмдгийг гардуулж баяр хүргэсэн бол 23 настай Зоригтбаатарын Тэмүүлэнг “Хамгийн залуу Хүндэт донор”-оор онцлон алдаршуулсан юм.



Монгол Улсын Цус сэлбэлт судлалын салбар, хүмүүнлэгийн чиглэлээр олон жил үр бүтээлтэй ажиллаж амжилт гаргасан Донор зохион байгуулалтын тасгийн донор зохион байгуулалт хариуцсан мэргэжилтэн Р.Энхтуяа, Үйлдвэрлэлийн тасгийн технологич сувилагч Л.Өлзийбаяр, Б.Өнөрцэцэг, Б.Дуламсүрэн, Н.Энхтуул, Нэгдсэн лабораторийн тасгийн лаборант С.Ганчимэг, Монголын донорын холбоо ТББ-ын ахмад ажилтан Р.Цэрэнпил нарыг Цусны албаны “Хүндэт тэмдэг”-ээр шагнаж байр хүргэлээ.



### Хүндэтгэлийн концерт:

Цусны донорын Дэлхийн өдрийн Хүндэтгэлийн арга хэмжээнд оролцсон хүндэт зочид, эрхэм цусны донорууд, цусны донорын үйлсийн дэмждэг нийт байгууллага хувь хүмүүст зориулж хамтран зохион байгуулагч Баянзүрх дуургийн ИТХ, ЗДТГ, Жанжин клубийн хамт олон Хүндэтгэлийн концерт толилуулж, баяр хүргэсэн юм.



**3. 2024 оны цусны донорын Дэлхийн өдрийн арга хэмжээг хэвлэл мэдээллийн байгууллагууд мэдээлэв.**

2024 оны ЦДДӨ-ийг тэмдэглэн өнгөрүүлэх хүндэтгэлийн арга хэмжээнд МҮОНТВ, МҮОНР, UBS, Өлзий ТВ, NTV, Eagle tv, Стар ТВ, МОНЦАМЭ агентлаг, MNB.mn, Burged 61 сайт, newswire.mn зэрэг хэвлэл мэдээллийн 20 гаруй байгууллага хүрэлцэн ирж мэдээ бэлтгэсэн ба төвийн ерөнхий захирал, Захиргаа, маркетингийн албаны дарга, ахмад хүндэт донорын төлөөлөл, шинээр хүндэт донорын болзол хангасан донор зэрэг давхардсан тоогоор 10 гаруй төлөөлөл сайн дурын авлагагүй цусны донор үйлс, цусны донорын Дэлхийн өдрийн 20 жилийн ойн арга хэмжээний онцлогийн талаар ярилцлага өгч олон нийтэд мэдээлэл сурталчилгаа хийж цусны донорын эгнээнд нэгдэх, цус, цусан бүтээгдэхүүний байнгын нөөцийг бүрдүүлэхэд иргэд, байгууллага хамт олныг оролцохыг уриаллаа.

Төвийн веб сайт, пейж хуудас, Амьдрал бэлэглэе, Донор та баатар группээр ёслол хүндэтгэлийн арга хэмжээ болон Цусны донорын Дэлхийн өдрийн 20 жилийн ойг тохиолдуулан тодруулсан шилдгүүд, хүндэт доноруудыг алдаршууллаа.

№	Хэвлэл мэдээллийн хэрэгслийн нэр	Мэдээллийн хэлбэр	Мэдээлэл өгсөн хүн
1.	МҮОНТВ	ярилцлага	<ul style="list-style-type: none"> <li>ЦССҮТ-ийн захирал Н.Эрдэнэбаяр</li> </ul>
2.	МҮОНР	ярилцлага	<ul style="list-style-type: none"> <li>Топ донор Д.Бум-Эрдэнэ</li> </ul>
3.	UBS	ярилцлага	<ul style="list-style-type: none"> <li>ЦССҮТ-ийн захиргаа, маркетингийн албаны дарга Ч.Батболд</li> <li>Донор Г.Жамц</li> <li>Ахмад донор</li> </ul>
4.	Өлзий ТВ	ярилцлага	<ul style="list-style-type: none"> <li>Топ донор Д.Бум-Эрдэнэ</li> <li>Топ донор Д.Эрдэнэчбулуун</li> <li>Алтан донор Д.Бүдханд</li> </ul>
5.	NTV	ярилцлага	<ul style="list-style-type: none"> <li>ЦССҮТ-ийн захиргаа, маркетингийн албаны дарга Ч.Батболд</li> <li>Топ Донор Д.Бум-Эрдэнэ</li> <li>Шударга журам медалаар шагнагдсан Алтан донор С.Соддэлгэр</li> </ul>
6.	Eagle tv	ярилцлага	<ul style="list-style-type: none"> <li>ЦССҮТ-ийн захирал Н.Эрдэнэбаяр</li> <li>Шинээр хүндэт донорын болзол хангасан хүндэт доноруудын төлөөлөл</li> </ul>
7.	Стар тв	ярилцлага	<ul style="list-style-type: none"> <li>ЦССҮТ-ийн захиргаа, маркетингийн албаны дарга Ч.Батболд</li> </ul>
8.	МОНЦАМЭ	Нийтлэл	<ul style="list-style-type: none"> <li><a href="https://www.montsame.mn/">https://www.montsame.mn/</a> сайтанд нийтлэл тавигдсан</li> </ul>
9.	MNB.mn	Мэдээ	<ul style="list-style-type: none"> <li><a href="https://www.mnb.mn/i/313138">https://www.mnb.mn/i/313138</a> сайтад мэдээ тавигдсан</li> </ul>
10.	Burged 61 сайт	Мэдээ	<ul style="list-style-type: none"> <li><a href="https://burged61.mn/p/7804">https://burged61.mn/p/7804</a> мэдээ тавигдсан</li> </ul>

11.	<a href="https://newswire.mn">https://newswire.mn</a>	Нийтлэл	<ul style="list-style-type: none"> <li>• <a href="https://newswire.mn/n/36125">https://newswire.mn/n/36125</a> сайтад тавигдсан</li> </ul>
12.	Баянзүрх өсвөрийн улаан загалмайчид	Нийтлэл шууд дамжуулалт	<ul style="list-style-type: none"> <li>• Цахим, фото сурвалжилга</li> </ul>
13.	ЦССҮТ	сурвалжлаг	ЦССҮТ-ийн пейж хуудсанд сурвалжлаг тавигдсан



## 5. Цусны донорын Дэлхийн өдрөөр хийгдсэн сургалт сурталчилгааны материал

№	Нэр	Тоо	Нэгж үнэ /₮/	Нийт үнэ /₮/	Тайлбар
1.	Зөвлөмж-1	2500	410	1,025,000	Зураг 1
2.	Зөвлөмж-2	2500	410	1,025,000	Зураг 2
3.	Плакат А2, А3	1400	1500	2,100,000	Зураг 3, 4
4.	Нугалбар	3000	391	1,173,000	Зураг 5
5.	Тэмдэглэлийн хуудас олшруулах, түгээх	450	2,860	1,287,000	Зураг 6
6.	Жилийн онцлох донор алдаршуулах /Өргөмжлөл/	20	20,000	400,000	Зураг 7
7.	Цусны донорын дэлхийн өдрийн сурталчилгааны хэвлэл /3,50*4,71,/	2	240,000	480,000	Зураг 8
8.	Цусны донорын дэлхийн өдрийн сурталчилгааны хэвлэл /3,37*2,20/	2	150,000	300,000	Зураг 8
9.	Цусны донорын дэлхийн өдрийн сурталчилгааны хэвлэл /3,37*2,57/	1	178,000	178,000	Зураг 8
10.	Цусны донорын тэмдэглэлт өдрууд, донор алдаршуулалтын сурталчилгаа видео шторк	60 сек	4,000,000	4,000,000	Доргохон 7
11.	2024 оны “Онцлох донор”-ын сурталчилгааны хэвлэл	1	120,000	120,000	
12.	2024 оны Цусны донор хамт олон-ны сурталчилгааны хэвлэл	2	55,000	110,000	
13.	Баянзүрх-Цусны донор дүүрэг, Зэвсэгт хүчний хуурай замын цэргийн командлал, Этугэн Их Сургууль тус тус “Цусны донор хамт олон” сурталчилгааны хаяг хэвлэл	3	250,000	750,000	
14.	Цусны байнгын донорыг алдаршуулах сурталчилгааны хэвлэл	1	34471	34471	
15.	Цусны байнгын донорыг алдаршуулах бахархал 10,20 тэмдэг хийлгэх	40	6,000	240,000	
Нийт				12 978 000	

## Зураг 1

**ЦУСЫН АМЬДРАЛЫГИЙН БАРЛАГ**

ЦУСЫН ОДОНТЫН ДАРААГАА БАЯРЛАЛАА

ЦУСЫН ДОНОРЫН ТӨРЛҮҮД


## Зураг 2

**ЦУСЫН АМЬДРАЛЫГИЙН БАРЛАГ**


**ЦУСЫН ОДОНТЫН ДАРААГАА БАЯРЛАЛАА**

**ЦУСЫН ХҮЧИҮН БҮҮГЭЭГИЙН ӨЗҮҮТ**

## Зураг 3




## Зураг 4



### Зураг 5




Бусад: Хулдаасан хэвлэл. Зураг 8



# ЦУСНЫ ДОНОРЫН ДЭЛХИЙН ӨДӨР

2024 ОНЫ 6 САРЫН 14



# ЦУСНЫ ДОНОРЫН ДЭЛХИЙН ӨДӨР

2024 ОНЫ 6 САРЫН 14

НЭГДСЭН ТАЙЛАН БИЧСЭН:

ЦССҮТ-ИЙН ЗАХИРГАА,  
МАРКЕТИНГИЙН АЛБАНЫ ДАРГА

2024.06.18